

Ирээд, Намайг дага

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэр бүлийн үдэш, судраас суралцах, зугаатай үйл ажиллагаа зэрэгт зориулав!



2-р сарын 26-аас 3-р сарын 3

Цаасан ариун сүм

2 НИФАЙ 11-19-Д ЗОРИУЛАВ

Ариун сүм бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай суралцдаг онцгой газар хэмээн Исаиа заасан (2 Нифай 12:3-ыг үзнэ үү). Өөрийн ариун сүмийг хийгээрэй! Цаасаа гурав нугалаад, нэг үзүүрийг нь гурвалжилж хайчил. Цаасаа дэлгээд голд нь өөрийгөө зураарай.

Бага насны хүүхдүүдэд: Хамтдаа ариун сүмийн зургийг хар. Бурханы өргөөнд яг л гэртээ байгаа юм шиг хайрыг мэдэрч болох талаар ярилцаарай.

3-р сарын 4-10

Дуун гэрчлэл

2 НИФАЙ 20-25-Д ЗОРИУЛАВ

Исаиа Есүс Христийн талаар гэрчлэлээ хуваалцсан. Есүс бол миний хүч мөн миний дуу гэж тэр хэлсэн (2 Нифай 22:2-ыг). Чи Есүсийн тухай ямар ямар дуунд дуртай вэ? Яагаад тэдгээр дуунд дуртай талаараа ярилцаад, дараа нь хамтдаа дуулаарай!

Бага насны хүүхдүүдэд: “Есүсийн түүхүүдээс яриач” (Хүүхдийн дууны ном, 36) дууг хамтдаа дуул. Хүүхдэдээ Есүсийн зургийг бариулж, уг дуунд Түүний тухай дурдагдах бүрд зургийг өргүүлээрэй.



3-р сарын 11-17

Шат шатаар түүх ярих

2 НИФАЙ 26-30-Д ЗОРИУЛАВ

Тэнгэрлэг Эцэг бидэнд “шат шатаар” буюу бага багаар сурахад тусалдаг (2 Нифай 28:30). Хамтдаа дуртай судрын түүхээ нэг нэг өгүүлбэрээр ярь! Түүх дуусах хүртэл хүн бүр нэг нэг өгүүлбэр ээлжлэн хэлнэ.

Бага насны хүүхдүүдэд: Тэнгэрлэг Эцэг бидэнд Есүс Христийн тухай суралцахад тусалдаг. 48-р хуудас руу очоод зургийн хэсэг бүрийг нэг нэгээрээ ээлжлэн будаарай.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭЙТИ ДОКРИЛ

3-р сарын 18-24

Есүсийг дагах алхмууд

2 НИФАЙ 31-33-Т ЗОРИУЛАВ

Бид Есүс Христэд итгэн, наманчилж, баптисм хүртэн, Ариун Сүнсний бэлэг хүлээн авч, эцсээ хүртэл тэвчих үед Түүнийг дагадаг хэмээн Нифай заасан (2 Нифай 31-ийг үзнэ үү). Алхам бүрийг тус тусад нь цаасан дээр бичээд газарт тарааж тавь. Нэг хүүхэд нүдээ аниад 10 хүртэл тоолно. Тэр хооронд бусад нь нэг нэгээрээ цаасан дээр гишгэж зогсоно. Дараа нь нүдээ аньж тоолсон хүүхэд Есүсийг дагах алхмуудаас нэгийг нэрлэнэ. Тэр нэрлэсэн цаасан дээр гишгэж буй хүүхэд одоо тоолно.

Бага насны хүүхдүүдэд:

Бид Есүс Христэд итгэх үедээ Түүний хэлсэн зүйлийг дагадаг. Жагсаж зогсоод, тойрч алх. Хамгийн урд байгаа хүүхэд удирдана. Хүүхдүүд удирдаж байгаа хүүхдийг дуурайж алхана. Ээлжлээд удирдаарай!



3-р сарын 25-31

Христийн амилсны баярын сараана цэцэгс

ХРИСТИЙН АМИЛСНЫ БАЯРТ ЗОРИУЛАВ

Есүс Христийн ачаар бид нас барсныхаа дараа дахин амьдарна (Алма 40:22-25-ыг үзнэ үү). 17-р хуудас дээрх Христийн амилсны баярын сараана цэцэгсийг хий. Энэ долоо хоногийн турш Аврагчийг санан дурсахын тулд хийсэн цэцгүүдээ гэрийнхэндээ харагдах газарт тавиарай.

Бага насны хүүхдүүдэд: 46-р хуудас дээрх Христийн амилсны баярын түүхийг унш. Уншиж байхдаа хүүхдүүдээ Есүсийн зураг бүрийг хуруугаараа зааж өгөөрэй.

